Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 02 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ

Дд	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл
1	**Нэр** Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр	Олхонууд овгийн Галбадрахын Уганбаатар
2	**Хүсэлт гаргагчийн хаяг** Иргэний үнэмлэхэд байгаа хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, ... дугаар хороо, ... байр, ... тоот
3	**Төрсөн огноо** Төрсөн газар	➢ 1986 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр ➢ Ховд аймгийн Жаргалант сум
4	**Боловсрол** Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.	➢ Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, 2004-2011 он, Дээд, эрх зүйч, 2011 оны 06 дугаар сарын 16-ны өдөр. Дипломын дугаар D201114298 ➢ Улаанбаатар Эрдэм Их Сургууль, 2017-2021 он, Эрх зүйн магистр, 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр. Дипломын дугаар E20210325
5	**Ажил эрхлэлт** Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.	➢ Ажил олгогчийн нэр: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Засгийн газрын 12 дугаар байр, Утас: 51-262786, 7000 - 0222 Цахим хуудас: https://www.nhrcm.gov.mn/ Ажлын байрны нэр: Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга 2022 оноос хойш Ахлах референт 2021-2022 он Референт 2017-2021 он ➢ Ажил олгогчийн нэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Хаяг: Татан буугдсан Утас: - Цахим хуудас: - Ажлын байрны нэр: Хууль, эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн дарга 2016 он Тусгай хяналтын улсын байцаагч 2015-2016 он Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн 2011-2015 он
6	**Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал**	Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн

	Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ.	
7	**Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил** Хүсэлт гаргагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ. -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.	**<u>1. Албан тушаалын нэр:</u>** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга. 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс одоог хүртэл 4.1 жил **<u>Ажлын газрын хаяг:</u>** Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Засгийн газрын 12 дугаар байр, Утас: 51-262786, 7000 – 0222, вэб сайт: https://www.nhrcm.gov.mn/ **<u>Албан тушаалын тодорхойлолт:</u>** Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөнтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээллийг шалгах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах, хяналт тавих, хүний эрх, эрх чөлөө зөрчсөн асуудлаар хяналт шалгалт хийж, Комиссын гишүүний зөвлөмж, шаардлага хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах. *(Албан тушаалын тодорхойлолтыг хавсаргасан.)* **<u>2. Албан тушаалын нэр:</u>** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн ахлах референт. 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 1.3 жил **<u>Ажлын газрын хаяг:</u>** Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Засгийн газрын 12 дугаар байр, Утас: 51-262786, 7000 – 0222, вэб сайт: https://www.nhrcm.gov.mn/ **<u>Албан тушаалын тодорхойлолт:</u>** Комиссын гишүүний чиглэл, удирдамжийн дагуу хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой анхаарал татсан асуудлаар санал, зөвлөмж, шаардлага, шүүхэд гаргах нэхэмжлэлийг боловсруулах, бүрдүүлбэрийг хангах, Комиссын гишүүний итгэмжлэлийн үндсэн дээр шүүхэд төлөөлөх. *(Албан тушаалын тодорхойлолтыг хавсаргасан.)* **<u>3. Албан тушаалын нэр:</u>** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн референт. 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 15-ний өдрийг хүртэл 4.5 жил **<u>Ажлын газрын хаяг:</u>** Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Засгийн газрын 12 дугаар байр, Утас: 51-262786, 7000 – 0222, вэб сайт: https://www.nhrcm.gov.mn/ **<u>Албан тушаалын тодорхойлолт:</u>** Комиссын гишүүний чиглэл, удирдамжийн дагуу гомдол, мэдээллийг шалгах, баримтжуулах, хүний эрхийн асуудлаар зөвлөгөө өгөх, хяналт шалгалт

		явуулах, гомдол, мэдээлэл, хяналт шалгалтын шийдвэрлэлттэй холбоотой албан бичиг болон Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн төсөл боловсруулах, эвлэрүүлэн зуучлах ажлыг хариуцаж, гүйцэтгэлийг хангах. *(Албан тушаалын тодорхойлолтыг хавсаргасан.)* **4. Албан тушаалын нэр:** Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хууль эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн дарга. 2016 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл 0.4 жил **Ажлын газрын хаяг:** Татан буугдсан **Албан тушаалын тодорхойлолт:** Мэргэжлийн хяналтын байгууллагын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, эдгээр чиглэлээр газрын дарга, удирдлагуудыг тайлан, мэдээлэл, судалгаа, бодлогын зөвлөмжөөр хангах. *(Албан тушаалын тодорхойлолтыг хавсаргасан.)* **5. Албан тушаалын нэр:** Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Тусгай хяналтын улсын байцаагч. 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 2016 оны 05 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл 1.0 жил **Ажлын газрын хаяг:** Татан буугдсан **Албан тушаалын тодорхойлолт:** Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн тусгай албан хаагчид ажилладаг, үйл ажиллагаа нь төрийн нууцын зэрэглэлд хамаарагддаг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд дахь батлан хамгаалах, аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт, мөрдөлтийн байдалд хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт өгөх. *(Албан тушаалын тодорхойлолтыг хавсаргасан.)* **6. Албан тушаалын нэр:** Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн. 2011 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл 3.6 жил **Ажлын газрын хаяг:** Татан буугдсан **Албан тушаалын тодорхойлолт:** Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох, мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтнуудад хууль, эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, хариуцсан чиглэлээр удирдлагыг мэдээлэл, судалгаа, зөвлөмжөөр хангах. *(Албан тушаалын тодорхойлолтыг хавсаргасан.)*

		Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт 4 жил 10 сар, Хүний эрхийн Үндэсний Комисст 9 жил 10 сар тус тус эрх зүйч мэргэжлээр ажилласан.
8	**Ёс зүй** Доор дурсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно. -сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх; -сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх.	➢ Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байгаагүй. (Сахилгийн шийтгэл хүлээж байгаагүй тухай тодорхойлолтыг хавсаргасан) ➢ Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй.
9	**Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар** Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ. -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.	**1. Байгууллагыг шүүхэд төлөөлөх ажилд оролцож байна. Улаанбаатар хот, 2023-2026 он** **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа**: Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2023 оны 01/259 дугаар албан бичгээр олгосон итгэмжлэлээр Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд, 2025 оны 01/2239 дугаар албан бичгээр олгосон итгэмжлэлээр Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргын шүүхэд тус тус хариуцагчаар оролцсон. **Үйл ажиллагааны гол агуулга**: Хүний эрхийн Үндэсний Комиссын гомдол шалгах ажиллагаатай холбоотой асуудлаар нэр бүхий иргэдээс нэхэмжлэл гаргасны дагуу хариуцагчаар оролцсон бөгөөд гомдол шалгах ажиллагааг хууль ёсны дагуу явуулсан тул нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй, маргааныг шүүхээр шийдвэрлүүлсэн. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ**: Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2026 оны 191/ШШ2026/10278 дугаар шийдвэрээр тус тус нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар**: Итгэмжлэл олгосон албан бичгүүд болон шүүхийн шийдвэрийг хавсаргасан. **2. Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаанд дагаж мөрдөх журмуудыг боловсруулж, батлуулсан. Улаанбаатар хот, 2022-2025 он.** **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2023 оны А/08 дугаар тушаалаар баталсан **“**Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн тухай гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажиллагааны журам”, 2025 оны А/60 дугаар тушаалаар баталсан “Хүний эрхийн Үндэсний Комиссын хяналт шалгалтын журам”-ыг тус тус хариуцан боловсруулж, 2026 оны А/59 дугаар тушаалаар баталсан “Хүний эрхийн Үндэсний Комиссын

		төрийн болон албаны нууц хамгаалах журам”-ыг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, батлуулсан. **Үйл ажиллагааны гол агуулга:** Хүний эрхийн Үндэсний Комиссын чиг үүрэгт 2022 онд хүний эрхийг хамгаалагчийн үйл ажиллагаа, хүний хувийн мэдээлэл хамгаалах үйл ажиллагаа нэмэгдсэнээр Комисст гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх, хяналт тавих үе шатыг илүү нарийвчилж тодорхойлох, гомдол шалгах ажиллагааны үе шат бүрийг журамлах шаардлага үүсч, тус журамд тусгасан. Мөн Хүний эрхийн Үндэсний Комиссын хяналт шалгалт хийх үйл ажиллагааг анх удаа журмаар нарийвчлан зохицуулсан. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** Гомдол шалган, шийдвэрлэх үйл ажиллагааг нарийвчилсанаар нэгж гомдлыг шийдвэрлэх хугацаа багассан. Мөн хяналт шалгалтын үйл ажиллагааг журамласнаар албан хаагчид ажиллахад ойлгомжтой, тодорхой болж, үр дүн сайжирсан. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:** Дээрх журмуудыг боловсруулах талаар Хүний эрхийн Үндэсний Комиссын сарын төлөвлөгөөнд тусгасан баримт, Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2023 оны А/08, 2025 оны А/59, А/60, 2026 оны А/28 дугаар тушаалуудын хуулбарыг хавсаргасан. **3. Цагдаагийн албаны “Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, шинжлэн үнэлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам”-ыг боловсруулах ажлын хэсэгт ажилласан. Улаанбаатар хот, 2023 он.** **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа**: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/161 дүгээр тушаалаар журмын төслийг боловсруулж, батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан. **Үйл ажиллагааны гол агуулга**: Улсын Их Хурлаас 2021 онд Нийтийн мэдээллийн ил, тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг баталсантай холбогдуулан цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчил, ял шийтгэлийн мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, хүлээн авах, хуваарилах, цахим болон цаасан суурьтай сан үүсгэх, түүнээс лавлагаа өгөхтэй холбоотой харилцааг зохицуулах журмыг шинэчилсэн. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ**: Тус журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/410 дугаар тушаалаар баталж, мөрдөж байна. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар**: Ажлын хэсэг байгуулсан тушаалын хуулбарыг хавсаргасан. Батлагдсан журамтай танилцах холбоос: https://legalinfo.mn/mn/detail?lawId=171421822458 51&showType=1 **4. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан. Улаанбаатар хот, 2022-2023 он.** **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа**: Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга,

		Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 2022 оны А/38, А/74 дүгээр тушаалаар ажлын хэсэгт ажилласан. **Үйл ажиллагааны гол агуулга**: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтад заасан эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулах, цахим орчинд хүний эрх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр санал боловсруулсан. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ**: Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/81 дугаар тушаалаар “Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журам”, А/90 дүгээр тушаалаар “Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам”-ыг тус тус баталсан. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар**: Ажлын хэсэг байгуулсан тушаалын хуулбарыг хавсаргасан. Батлагдсан журмуудтай танилцах холбоос: https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760452494481 https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760452348261 **5. “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхдийн эрх” хэлэлцүүлэгт модератор болон панелистаар ажилласан. Улаанбаатар хот, 2022 он.** **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа**: Хүний эрхийн Үндэсний Комиссоос зохион байгуулсан **“**Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхдийн эрх” хэлэлцүүлгийн нээлтийн арга хэмжээний модератор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь хүүхдийн эрхийн асуудал салбар хэлэлцүүлэгт панелистаар ажилласан. **Үйл ажиллагааны гол агуулга**: Эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь хүүхдийн эрхийн зөрчил, тулгамдсан асуудлыг тодорхойлсон. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ**: Хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлж, Улсын Их хурлаас 2024 онд баталсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29 дүгээр зүйлд зарчмын саналууд орсон. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар**: Хэлэлцүүлгийн хөтөлбөрийг хавсаргасан. **6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан. Улаанбаатар хот, 2022 он.** **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа**: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/72 дугаар тушаалаар Зөрчлийн болон эрүүгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгохтой

		холбогдуулан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт, А/73 дугаар тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт тус тус ажилласан. **Үйл ажиллагааны гол агуулга**: Эрүүгийн болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг иргэний болон захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас тусгаарлах эрх зүйн зохицуулалтыг бий болгох. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ**: Ажлын хэсэгт ажиллаж, хуулийн төсөлд оруулах Комиссын саналыг хүргүүлсэн. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар**: Ажлын хэсэг байгуулсан тушаалуудын хуулбарыг хавсаргасан. **7. Уралдааны хүүхдийн эрх зүйн зохицуулалт, дүрэм журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ажилласан. Улаанбаатар хот, 2021 он.** **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа**: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/123 дугаар тушаалаар хурдан морины уралдааны хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах хамгаалахтай холбогдсон хууль эрх зүйн зохицуулалт, дүрэм журмыг шинэчлэн боловсруулах чиг үүрэг бүхий салбар дундын ажлын хэсэгт ажилласан. **Үйл ажиллагааны гол агуулга**: Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйл, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай 182 дугаар конвенц, Насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенц, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоол, Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын А/36 дугаар тушаалаар баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг тус тус үндэслэн Үндэсний их баяр наадмын тухай хууль, Үндэсний баяр наадмын хурдан морины уралдаан зохион байгуулах дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, хурдан морь уралдааны хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн орчныг сайжруулах. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ**: Унаач хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах үүднээс хүйтний улиралд хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байх талаар 21 аймгийн Засаг даргад хүргүүлэх Комиссын гишүүний зөвлөмжийг санаачлан, боловсруулж хүргүүлсэн. Мөн Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийн гуравдугаар бүлгийн 3.3 дахь “Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал” дэд бүлгийн “Хурдан морь унаач хүүхдийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал” хэсгийг боловсруулж, Улсын Их Хурлын 2022 оны 49 дугаар тогтоолоор хурдан морины унаач хүүхдийн эрхийг хамгаалах талаар холбогдох арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар**: Ажлын хэсэг байгуулсан тушаал, Комиссын гишүүний 2022 оны 05/02 дугаар зөвлөмж, Улсын Их Хурлын 2022 оны 49 дугаар тогтоолын хуулбарыг хавсаргасан.

		8. Эрх зүйн магистрын зэрэг хамгаалсан. Улаанбаатар хот, 2017-2021 он. **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа**: Улаанбаатар Эрдэм их сургуулийн захирлын 2021 оны 01 дүгээр сарын 03 дугаар тушаалаар Е20210325 дугаартай магистрын диплом олгосон. **Үйл ажиллагааны гол агуулга**: Магистрын зэргийг “Хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал” сэдвээр диплом бичиж, хамгаалсан. Дипломын ажил нь удиртгал, 2 бүлэг, дүгнэлт, санал, хавсралт, ном зүй гэсэн хэсгээс бүрдсэн. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ**: Хөдөлмөрийн харилцаанд үүсч буй жендэрийн ялгавралан гадуурхалтын шалтгаан нөхцөл, түүнийг хэрхэн арилгах саналыг тохиолдол, судалгаа, дүн шинжилгээний үндсэн дээр дэвшүүлсэн. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар**: Магистрын дипломын хуулбарыг хавсаргасан. **9. Улсын ерөнхий байцаагчийн удирдамжаар хяналт шалгалт хийсэн. Улаанбаатар хот, 2015 он.** **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа**: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, улсын ерөнхий байцаагчийн 2015 оны 01/149 дугаартай удирдамжаар батлагдсан ажлын хэсэгт ажилласан. **Үйл ажиллагааны гол агуулга**: Аж ахуй нэгж, иргэд тээврийн хэрэгсэлдээ зөвшөөрөлгүй болон албан бус зөвшөөрөлтэй тусгай дуут дохио ашиглаж улсын дугаарын хязгаарлалтад орохгүй байгаа зөрчлийг таслан зогсоох. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ**: Шалгалтын үр дүнг ерөнхий байцаагчид танилцуулж, Хууль зүйн сайдын 2013 оны А/121 дугаар тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам”, “Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавих ба хэрэглэх” MNS 4979:2000 стандартын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар**: Хяналт шалгалтын удирдамжийн хуулбарыг хавсаргасан. **10. Зөрчлийн тухай хууль боловсруулах ажлын хэсэгт ажилласан. Улаанбаатар хот, 2012-2015 он.** **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа**: Хууль зүйн сайдын 2012 оны А/33, А/65 дугаар тушаалаар Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт, А/77 дугаар тушаалаар Захиргааны хариуцлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт, тус

		сайдын 2013 оны А/258 дугаар тушаалаар Захиргааны хариуцлагын тухай /Зөрчлийн тухай/ хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт тус тус ажилласан. **Үйл ажиллагааны гол агуулга**: Тус тусын хуулиар зохицуулж байсан захиргааны хариуцлагын тогтолцоог нэгдсэн нэг хуулиар буюу Зөрчлийн тухай хуулиар анх удаа зохицуулсан. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ**: Тус хуулийг Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн чуулганы хуралдаанаар баталж, 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтоосон бөгөөд 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдөр хэрэгжих хугацааг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хойшлуулсан. Улмаар тус хуулийг Улсын Их Хурлын 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн чуулганы хуралдаанаар хүчингүй болгож Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж байна. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар**: Ажлын хэсэг байгуулсан тушаалуудын хуулбарыг хавсаргасан. Батлагдсан хуультай танилцах холбоос: https://legalinfo.mn/mn/detail?lawId=11645
10	**Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил** Хүсэлт гаргагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.	**Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа:** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн референтээр 2017-2021 онд, ахлах референтээр 2021-2022 онд, хэлтсийн даргаар 2022 оноос хойш, Нийт 9 жил 10 сар ажиллаж байна. Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Засгийн газрын 12 дугаар байр. Энэ хугацаанд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэж, жил бүрийн үр дүнгийн үнэлгээгээр “А” үнэлэгдэж байсан. Үүнд: 1. Хүний эрхийн Үндэсний Комисст 2022 оноос 2026 оны 3 дугаар улирлын байдлаар иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас 5700 гомдол, мэдээлэл ирүүлснийг хүлээн авч, шалгах ажиллагаа явуулахад удирдлага, зохион байгуулалтаар хангах, ажилтнуудад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, гомдол шийдвэрлэх ажиллагааг тогтоосон хугацаанд явуулахад хяналт тавьж, ажилласан. 2. 2022 оноос хойш Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүний эрхийг хамгаалах чиглэлээр 786 хяналт шалгалт хийсэн бөгөөд үүнээс 203 хяналт шалгалтын ажлын хэсэгт ажиллаж, 21 хяналт шалгалтыг ахалж ажилласан байна. 3. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасан гишүүний бүрэн эрхийн хүрээнд хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох чиглэлээр хүргүүлсэн 121 шаардлага, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүргүүлсэн 245 зөвлөмжийг тус тус хянаж, 24 шаардлагын төсөл, 39 зөвлөмжийн төслийг хариуцан боловсруулж албажуулсан байна. (Дээрх 3 ажилтай холбогдуулан сүүлийн 5 жилийн үр дүнгийн үнэлгээний хуудсын хуулбарыг хавсаргасан.) 4. Хүний зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирол нөхөн төлүүлэх зорилгоор Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргаж буй төлөөлөн нэхэмжлэлийг боловсруулах, шүүх хуралдаанд итгэмжлэлээр оролцох ажлыг гүйцэтгэж байна. (Хүний эрхийн Үндэсний

		Комиссын гишүүний төлөөлөн нэхэмжлэлд итгэмжлэлээр оролцсон албан бичгийн хуулбарыг хавсаргасан.) 5. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст хэрэгжүүлэх Ажлын хэсэгт ажилласан. Тус төслийг 6 жилийн хугацаанд жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлснээр нийт 254 хяналт шалгалт зохион байгуулж, холбогдох албан тушаалтнуудад Комиссын гишүүний 4 шаардлага, 30 зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг хянасан. Түүнчлэн 420 албан хаагчийг сургагч багшаар бэлтгэж, 2 судалгааны ажлыг гүйцэтгүүлж, судалгааны үр дүнг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Төрийн тусгай болон үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн төлөв байдал” дэд бүлэгт тусгасан. (Төслийн ажлын хэсэгт ажилласан тушаалын хуулбарыг хавсаргасан.) **Ажлын байрны тодорхойлолт:** Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөнтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээллийг шалгах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах, хяналт тавих, хүний эрх, эрх чөлөө зөрчсөн асуудлаар хяналт шалгалт хийж, Комиссын гишүүний зөвлөмж, шаардлага хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах.
11	**Хүний эрхийг хүндэлж, дээдэлдэг байдал** Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар	**1. Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 9 илтгэлийг боловсруулах ажлын хэсэгт ажилласан. Улаанбаатар хот, 2017-2026 он.** **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа**: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад заасан “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл боловсруулж, Улсын Их Хуралд хүргүүлэх” чиг үүргийн хүрээнд Комиссын даргын тушаалаар 9 удаагийн илтгэлийг боловсруулах ажлын хэсэгт ажилласан. Үүнд: 1. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх:байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт ба иргэдийн оролцоо” ХЭҮК, 2018 он. 2. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл “Хилийн боомтод ажиллаж буй мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал” ХЭҮК, 2018 он. 3. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл “Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт” ХЭҮК, 2019 он. 4. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэл “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт” ХЭҮК, 2020 он. 5. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл “Амьд явах, халдашгүй чөлөөтэй байх эрх” ХЭҮК, 2021 он. 6. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл “Гэр бүлийн

		хүчирхийллээс ангид байх эрх” ХЭҮК, 2022 он. 7. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл “Ахмад настны эрхийн хэрэгжилт” ХЭҮК, 2023 он. 8. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийн зарим асуудал” ХЭҮК, 2025 он. 9. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэл “Шүүх шинжилгээ ба Хүний эрх” ХЭҮК, 2026 он. **Үйл ажиллагааны гол агуулга**: Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан зарим эрхийн асуудлыг тодорхойлж, Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэлийг жил бүр боловсруулж, саналын хамт Улсын Их Хуралд өргөн барьсан. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ**: Илтгэлийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж Улсын Их Хурлын 2019 оны 62, 2021 оны 67, 2022 оны 49, 2023 оны 35, 2025 оны 77, 2026 оны 25 дугаар тогтоол гарсан. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар**: Илтгэл боловсруулах ажлын хэсэг байгуулсан Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2019 оны А/02, 2021 оны А/03, 2022 оны А/05, 2023 оны А/01, 2024 оны А/36, 2025 оны А/59 дугаар тушаалуудын хуулбарыг хавсаргасан. Илтгэлтэй танилцах холбоос: https://nhrcm.gov.mn/#/page/29/journal/list/29 **2. “Хүний эрхийн Нээлттэй өдөр” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэгт ажилласан. 21 аймаг, 2017-2026 он.** **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа**: Хүний эрхийн Үндэсний Комиссоос 21 аймаг, зарим сумд, алслагдсан дүүргүүдэд зохион байгуулдаг “Хүний эрхийн Нээлттэй өдөр” арга хэмжээнд 23 удаа хяналт шалгалт хийх, иргэдэд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, гомдол, мэдээлэл хүлээн авах, сургалт хийх чиг үүрэгтэйгээр оролцсон. **Үйл ажиллагааны гол агуулга**: Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын хүний эрхийн гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилт, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, хяналт шалгалт хийх, олон нийтэд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, уулзалт зохион байгуулах, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах, төрийн байгууллага, албан тушаалтнуудын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, Комиссын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах цогц арга хэмжээ юм. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ**: Нээлттэй өдрийн хүрээнд хийгдсэн хяналт шалгалт, дүн шинжилгээ, иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг үндэслэн тухайн аймгийн Засаг даргад Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж хүргүүлдэг бөгөөд 15 аймгийн Засаг даргад хүргүүлэх шаардлага, зөвлөмжийг боловсруулсан. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар**: Нээлттэй өдөр арга хэмжээний удирдамж, томилолтоор ажилласан тушаалын хуулбарыг хавсаргасан.

		3. Хүний эрхийн сургалт зохион байгуулсан. Улаанбаатар хот, 21 аймаг, 2017-2026 он. **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтад заасан “Хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх” чиг үүргийн хүрээнд хүний эрхийн сургалт зохион байгуулсан. **Үйл ажиллагааны гол агуулга:** Хүний эрхийн Үндэсний Комиссоос бэлтгэж буй сургагч багшийн сургалт болон төлөвлөгөөт, захиалгат сургалтуудад “Хүний эрхийн үндсэн ойлголт”, “Хүний эрхийн зөрчил”, “Хөдөлмөрлөх эрх”, “Ажлын байрны дарамтаас урьдчилан сэргийлэх”, “Жендэр ба хүний эрх”, “Хүний эрхийн Үндэсний Комиссын гомдол, шийдвэрлэлт” зэрэг сэдвээр сургалт хийсэн. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** Дээрх сургалтуудад хамрагдсан оролцогчдын хүний эрхийн тодорхой сэдвийн талаарх мэдлэг, ойлголт нэмэгдсэн. Нийт 68 төрийн албан хаагчийг сургагч багшаар бэлтгэсэн. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар**: Жишээ болгож зарим сургалтын хөтөлбөрийн хуулбарыг хавсаргасан. **4. Байгууллагын Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүнээр ажилласан. Улаанбаатар хот, 2019-2026 он.** **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу байгуулагдсан Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны Ёс зүйн зөвлөлийн дарга, гишүүнээр, Төрийн албаны хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу байгуулагдсан Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүнээр тус тус хамт олны олонхийн саналаар сонгогдон тасралтгүй ажиллаж байна. Үүнд: 1. Ажлын албаны даргын 2019 оны А/05 дугаар тушаалаар Ёс зүйн зөвлөлийн гишүүнээр, 2. Тамгын газрын даргын 2021 оны А/07 дугаар тушаалаар Ёс зүйн зөвлөлийн даргаар, 3. Тамгын газрын даргын 2022 оны А/29 дүгээр тушаалаар Ёс зүйн зөвлөлийн гишүүнээр, 4. Тамгын газрын даргын 2023 оны А/113 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хорооны даргаар, 5. Тамгын газрын даргын 2025 оны А/24 дүгээр тушаалаар Ёс зүйн дэд хорооны гишүүнээр, 6. Тамгын газрын даргын 2025 оны А/134 дүгээр тушаалаах Ёс зүйн дэд хорооны даргаар тус тус ажиллаж байна. **Үйл ажиллагааны гол агуулга:** Төрийн албаны хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа төлөвлөн, зохион байгуулах чиг үүрэгтэй ажиллаж байна. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** Ёс зүйн зөвлөл, дэд хороонд ирүүлсэн гомдлыг

		хянан шийдвэрлэх, байгууллагын албан хаагчдыг соён гэгээрүүлэх, сургалтад хамруулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, Монгол Улсын Ёс зүйн хороонд жил бүр тайлан хүргүүлж ажилласан. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:** Ёс зүйн зөвлөл болон Ёс зүйн дэд хороонд ажилласан тушаалуудын хуулбарыг хавсаргасан. Ёс зүйн дэд хорооны мэдээлэлтэй танилцах холбоос: https://nhrcm.gov.mn/#/page/246/post/view/4480 **5. Жагсаал, цуглааны үйл ажиллагаанд хяналт, мониторинг хийсэн. Улаанбаатар хот, 2022-2026 он.** **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтад заасан “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах” чиг үүргийн хүрээнд 2022 оноос хойш олон нийтийг хамарсан жагсаал, цуглааны үйл ажиллагаанд тогтмол хяналт, мониторинг хийж, иргэдийн тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалан ажилласан. **Үйл ажиллагааны гол агуулга:** Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх”-ийг баталгаажуулсан. Иргэд энэхүү эрхээ бодитоор эдэлж чадаж байгаа эсэх, тайван замаар жагсаал цуглаан хийж байгаа иргэдийн үйл ажиллагаанд үймээн самуун үүсэж, улмаар хүний эрхийн зөрчил гарч болзошгүй нөхцөл байдлыг хянасан. **Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** Жагсаал цуглааны үеэр биечлэн хяналт тавьж, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй асуудлаар цагдаагийн байгууллагатай мэдээлэл солилцож, эрсдэлийг бууруулсан. Хяналт, мониторингийн үр дүнгийн талаар олон нийтэд тухай бүр мэдээлэл хүргэж ажилласан. **Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:** Олон нийтийг хамарсан жагсаал цуглааны үед ажиллах удирдамж, ажил үүргийн хуваарийн хуулбар, жагсаалд хяналт тавьсан асуудлаар олон нийтэд өгсөн зарим мэдээллийг хуулбарлан хавсаргасан. Мэдээлэлтэй танилцах холбоос. https://graph.mn/news/3191 https://zogii.mn/newsm/8/2/199087 https://ikon.mn/n/38ao Жагсаал цуглааны үеэр олон нийтэд хандасан уриалгатай танилцах холбоос: https://www.facebook.com/watch/?v=1172664177560930&rdid=7zFGrqyIaXa64r5j. **6. Ерөнхий хяналтын сонсголд Хүний эрхийн Үндэсний Комисоос танилцуулах мэдээллийг бэлтгэж, оролцсон. Улаанбаатар хот. 2024-2026 он.** **Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” сэдэвт сонсгол, 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан “Агаарын бохирдолыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого,

